

## **ИНКОТЕРМС-2000**

### **1. Е БҮЛГИЙН НӨХЦӨЛ**

**EXW-Ex Works (...named place)**

**EXW- Үйлдвэрээс нийлүүлэх (нэрлэсэн газар)**

**Ex Works** гэдэг нь худалдагч тухайн барааг худалдан авагчийн мэдэлд нэрлэсэн газарт /худалдан авагчийн ажил, үйлдвэр гэх мэт газарт/ хүргэж өгөхийг хэлнэ.

Энэхүү худалдааны нөхцлийн дагуу худалдагч маш бага үүрэг хүлээдэг ба худалдан авагч худалдагчийн утгвар нөхцлийн үндсэн дээр тухайн барааны бүх зардал, эрсдлийг хариуцна. Хэрэв талуудын тохиролцооны дагуу худалдагч барааг ачуулах, мөн түүнчлэн барааг ачуулахтай холбоотой зардал, эрсдлийг хариуцах үүрэг хүлээсэн бол энэ тухай заалтыг худалдах худалдан авах гэрээндээ тусгах нь зүйтэй.

Энэ нөхцөл нь худалдан авагч шууд болон шууд бус экспортын үйл ажиллагааг эрхлэх бололцоогүй үед хэрэглэгдэхгүй. Энэ тохиолдолд FCA нөхцлийн хэрэглэнэ.

#### **A ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

##### **A 1. Бараа**

Худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааг нийлүүлэх мөн худалдааны нэхэмжлэх эсхүл түүнтэй адилтгах электрон бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй.

##### **A 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдан авагчийн хүсэлтээр эрсдэл ба зардлыг хариуцаж, зөвшөөрөл лиценз болон бусад баримт бичиг авахад бүхий л туслалцааг үзүүлнэ.

##### **A 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдагч барааг тээвэрлэх ба даатгуулах ямар ч үүрэг хүлээхгүй.

##### **A 4. Нийлүүлэлт**

Худалдагч нэрлэсэн газарт барааг худалдан авагчийн мэдэлд хүргэж өгөх үүрэгтэй.

##### **A 5. Эрсдэл шилжих**

Худалдагч нэрлэсэн газарт барааг худалдан авагчид шилжүүлэх хүртэл бараа гэмтэх, алга болох бүх эрсдлийг хариуцна.

##### **A 6. Зардал**

Худалдагч нэрлэсэн газарт барааг худалдан авагчид шилжүүлэх хүртэл бүх зардлыг төлнө.

**A 7. Худалдан авагчид мэдэгдэх**

Худалдагч худалдан авагчид барааг шилжүүлэх газар, хугацааг мэдэгдэх үүрэгтэй.

**A 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээвэрийн баримт бичиг**

Худалдагч худалдан авагчид нийлүүлэлт, тээвэрлэлтийн нотолгоо өгөх ямар нэг үүрэггүй.

**A 9. Шалгах, сав баглаа боодол, шошго**

Худалдагч гэрээний дагуу барааны чанар, тоо хэмжээг шалгахтай холбоотой бүх зардлыг төлнө. Худалдан авагч худалдагчид тээвэрлэлтийн нөхцлийг урьдчилсан хэлсний дагуу сав баглаа боодлыг хариуцна. Сав баглаа боодолд тохирсон шошго хадна.

**A 10. Бусад үүрэг**

Худалдагч Худалдан авагчийн хүсэлтээр экспорт, импортод шаардлагатай баримт бичгийг өгнө. Худалдан авагчийн хүсэлтээр даатгал хийхэд шаардлагатай мэдээллийг өгөх үүрэгтэй.

**В. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ**

**В1. Төлбөр**

Худалдан авагч худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааны үнийг төлөх үүрэгтэй.

**В 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдан авагч экспорт, импортын зөвшөөрөл, баримт бичгийн бүх эрсдэл, зардлыг өөрөө хариуцна. Барааг экспортлоход шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийг өөрийн зардал, эрсдлээр хариуцна.

**В 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдан авагч барааг тээвэрлэх ба даатгуулах ямар ч үүрэг хүлээхгүй.

**В 4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдан авагч A4 болон A7/B7-ийн дагуу нийлүүлэгдсэн барааг хүлээн авах үүрэгтэй.

**В 5. Эрсдэл шилжих**

Худалдан авагч бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг

- A4-ийн дагуу бараа нийлүүлэгдсэн үеэс
- Барааны нийлүүлэлтийг хүлээн авах талуудын тохиолцсон хугацаанаас эсхүл барааны нийлүүлэлтийг хүлээн авах тогтоосон хугацаа дууссан өдрөөс эхлэн хариуцна.

**В6. Зардал**

Худалдан авагч нь

- A4 дагуу барааг нийлүүлж хүлээн авснаас хойш гарсан бүх зардал,

- Гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн газарт барааны нийлүүлэлтийг хүлээж аваагүйгээс учирсан хохирол,
- Барааны экспортлохтой холбоотой татвар, хураамж болон гаалийн бүрдүүлэлтэй холбоотой бүхий л зардлыг төлөх үүрэгтэй.

Мөн худалдагч А2-ийн дагуу тусламж үзүүлсэн болон түүнтэй холбоотой гарсан зардлыг худалдагчид нөхөн төлөх үүрэгтэй.

#### **В7. Худалдагчид мэдэгдэл гаргах**

Худалдан авагч барааны нийлүүлэлтийг хүлээн авах, хугацааны талаар тодорхой, хангалттай мэдэгдлийг худалдагчид мэдэгдэх үүрэгтэй.

**В 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг болон тэдгээртэй адилтгах электрон мэдээлэл**

Худалдан авагч нийлүүлэлтийг хүлээн авснаа худалдагчид нотолно.

#### **В 9. Барааг шалгах**

Худалдан авагч барааг ачихаас өмнө хийх шалгалт, түүнээс гадна экспортын улсын эрх бүхий байгууллагын шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй.

#### **В10. Бусад үүрэг**

Худалдан авагч А4-ийн дагуу худалдагчаас экспорт импортоод шаардлагатай баримт бичгийг гаргуулсны зардлыг төлөх үүрэгтэй.

## **2. F БҮЛГИЙН НӨХЦӨЛҮҮД**

### **FAS нөхцөл**

**FAS, Free Alongside Ship (...named port of shipment)**

**FAS Усан онгоцны хашлагын дагуу чөлөөтэй (....ачаалах боомт )**

FAS гэдэг нь худалдагч барааг нэрлэсэн боомт дахь усан онгоцны хашлага хүргэж өгөхийг хэлнэ. Энэ нь тэр мөчөөс хойш худалдан авагч бүхий л зардал, эрсдэл, гарз болон хохирлыг хариуцна гэсэн үг юм.

FAS нөхцөл нь барааг экспортод гаргахад шаардлагатай бүх зардлаас худалдан авагчийг чөлөөлөх үүргийг худалдагчаас шаарддаг. Хэрэв талууд худалдан авагч тал худалдагчийг экспортод гаргахад шаардлагатай бүх зардлаас чөлөөлөхөөр хүсэж байвал гэрээндээ энэ талаар тусгаж өгөх ёстой.

Энэ нөхцөл нь зөвхөн далайн ба эх газрын усан тээвэрт хэрэглэгдэнэ.

### **А ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

#### **А 1. Бараа**

Худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааг нийлүүлэх мөн худалдааны нэхэмжлэх эсхүл түүнтэй адилтгах электрон бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй.

#### **А 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдагч экспортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг экспортод гаргахад шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийн өөрийн эрсдэл, зардлаар хариуцна.

**A 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдагч барааг тээвэрлэх ба даатгуулах ямар ч үүрэг хүлээхгүй.

**A 4. Нийлүүлэлт**

Худалдагч барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн ачаалах боомт дээр худалдан авагчийн нэрлэсэн усан онгоц дээр худалдан авагчийн тодорхойлсон хашлага хүртэл барааг хүргэж өгөх үүрэгтэй.

**A 5. Эрсдэл шилжих**

Худалдагч А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бараа алга болох гэмтэх бүх эрсдлийг хариуцна.

**A 6. Зардал**

Худалдагч нь

- А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бүх зардал,
- Экспортын гаалийн бүрдүүлэлт, мөн экспорттой холбоотой татвар хураамж болон бусад зардлыг төлөх үүрэгтэй.

**A 7. Худалдан авагчид мэдэгдэх**

Худалдагч нэрлэсэн усан онгоцны хашлага хүртэл барааг хүргэсэн тухай худалдан авагчид мэдэгдэх үүрэгтэй.

**A 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээвэрийн баримт бичиг**

Худалдагч нийлүүлэлтийн баталгаа буюу тээвэрлэлтийн баримт бичгийг худалдан авагчид өгөх бөгөөд тээвэрлэлтийн баримт бичиг авахад худалдан авагчид тусална.

**A 9. Шалгах, сав баглаа боодол, шошго**

Худалдагч гэрээний дагуу барааны чанар, тоо хэмжээг шалгахтай холбоотой бүх зардлыг төлнө. Худалдан авагч худалдагчид тээвэрлэлтийн нөхцлийг урьдчилсан хэлсний дагуу сав баглаа боодлыг хариуцна. Сав баглаа боодолд тохирсон шошго хадна.

**A 10. Бусад үүрэг**

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспортын орны гаргах баримт бичиг буюу импортод шаардлагатай гарал үүслийн баримт бичгийг гаргаж өгнө. Худалдан авагчид даатгалтай холбоотой шаардагдах мэдээллээр хангана.

**B. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ**

**B 1. Төлбөр**

Худалдан авагч худалдах худалдан авах гэрээний дагуу барааны үнийг төлөх үүрэгтэй.

**B 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдан авагч импортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг импортлоход шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийг өөрийн эрсдэл, зардлаар хариуцна

**В 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдан авагч нэрлэсэн ачаалах боомтоос барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар хийнэ. Даатгал хийх үүрэггүй.

**В 4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдан авагч А4-ийн дагуу нийлүүлсэн барааг хүлээн авах үүрэгтэй.

**В 5. Эрсдэл шилжих**

Худалдан авагч бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг

- А4-ийн дагуу бараа нийлүүлэгдсэн үеэс
- Барааны нийлүүлэлтийг хүлээн авах талуудын тохиолцсон хугацаанаас эсхүл барааны нийлүүлэлтийг хүлээн авах тогтоосон хугацаа дууссан өдрөөс эхлэн хариуцна

**В 6. Зардал**

Худалдан авагч нь

- А4 дагуу барааг нийлүүлж хүлээн авснаас хойш гарсан бүх зардал,
- Түүний нэрлэсэн усан онгоц цагтаа ирээгүй эсхүл барааг хүлээн авах боломжгүй, эсхүл ачаа хүлээж авах цагийг мэдэгдсэн хугацаанаас өмнө хаасан тохиолдолд худалдан авагч энэ тухай зохих журмаар мэдэгдээгүй бол түүнээс учирсан хохирол,
- Барааны импортлохой холбоотой татвар, хураамж болон гаалийн бүрдүүлэлтэй холбоотой бүхий л зардлыг төлөх үүрэгтэй.

**В 7. Худалдагчид мэдэгдэл гаргах**

Худалдан авагч худалдагчид усан онгоцны нэр болон очих цаг хугацаа, газрын тухай мэдээллийг өгнө.

**В 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг болон тэдгээртэй адилтгах электрон мэдээлэл**

Худалдан авагч А8-ийн дагуу худалдагчаас өгөх нийлүүлэлтийн нотолгоог хүлээн авах үүрэгтэй.

**В 9. Барааг шалгах**

Худалдан авагч барааг ачихаас өмнө хийх шалгалт, түүнээс гадна экспортын улсын эрх бүхий байгууллагын шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй.

**В10. Бусад үүрэг**

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

## **FCA нөхцөл**

**FCA-Free Carrier (...named place)**

**FCA- Тээвэрлэх хүртэл чөлөөтэй (...нэрлэсэн газар)**

FCA нөхцөл гэдэг нь худалдагч нь худалдан авагчийн нэрлэсэн газарт түүний томилсон тээвэрлэгчийн мэдэлд экспортод нийцсэн барааг хүргэж өгөхийг хэлнэ.

Барааг хүргэхээр сонгосон газар нь тухайн барааны ачилт болон ачилтын бус үүрэгт нийцэхээр байх ёстойг анхаарах хэрэгтэй. Хэрэв худалдагч барааг хүргэж өгөхөөр урьдчилан тохиролцсон бол худалдагч түүнийг ачих үүргийг хүлээнэ. Хэрэв барааг өөр ямар нэгэн газарт хүргэхээр бол түүнийг ачих үүргийг худалдагч хүлээхгүй.

Энэхүү нөхцлийг бүх төрлийн тээврийн хэрэгсэл болон холимог тээвэрт хэрэглэж болно.

“Тээвэрлэгч” гэдэг нь тээвэрлэлтийн гэрээний дагуу барааг төмөр зам, авто зам, агаар, далай, эх газрын усан замын тээвэр эсхүл холимог тээврээр ачих, тээвэрлэх үүрэг хүлэсэн этгээдийг хэлнэ.

Хэрэв худалдагч ачигчаас өөр хэн хүнийг томилсон бол худалдагч тэр томилсон хүнд барааг хүлээлгэж өгснөөр барааг нийлүүлэх үүргээ гүйцэтгэсэнд тооцно.

## **А ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

### **А 1. Бараа**

Худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааг нийлүүлэх мөн худалдааны нэхэмжлэх эсхүл түүнтэй адилтгах электрон бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй.

### **А 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдагч экспортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг экспортод гаргахад шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийн өөрийн эрсдэл, зардлаар хариуцна.

### **А 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдагч барааг тээвэрлэх ба даатгуулах ямар ч үүрэг хүлээхгүй. Гэхдээ хэрэв худалдан авагч хүсвэл эсхүл худалдааны практикийн дагуу худалдагч худалдан авагчийн зардал эрсдлээр стандарт нөхцлөөр тээвэрлэлтийн гэрээг хийж болно. Хэрэв ингэх бол худалдагч худалдан авагчид мэдэгдэнэ.

### **А 4. Нийлүүлэлт**

Худалдагч барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн газар худалдан авагчийн томилсон тээвэрлэгч эсхүл өөр хүнд барааг хүргэж өгөх үүрэгтэй.

### **А 5. Эрсдэл шилжих**

Худалдагч А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бараа алга болох гэмтэх бүх эрсдлийг хариуцна.

**A 6. Зардал**

Худалдагч нь

- А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бүх зардал,
- Экспортын гаалийн бүрдүүлэлт, мөн экспорттой холбоотой татвар хураамж болон бусад зардлыг төлөх үүрэгтэй.

**A 7. Худалдан авагчид мэдэгдэх**

Худалдагч А4-ийн дагуу барааг нийлүүлсэн тухай худалдан авагчид мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв тогтоосон хугацаанд А4-ийн дагуу нийлүүлсэн барааг тээвэрлэгч хүлээн аваагүй бол энэ тухай худалдан авагчид мэдэгдэх үүрэгтэй.

**A 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээвэрийн баримт бичиг**

Худалдагч өөрийн зардлаар нийлүүлэлтийн баталгааг худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй. Худалдагч худалдан авагчийн хүсэлтийн дагуу, түүний эрсдэл зардлаар тээврийн баримт бичгийг гаргаж өгнө.

**A 9. Шалгах, сав баглаа боодол, шошго**

Худалдагч барааг нийлүүлэхэд шаардлагатай шалгалт /тухайлбал, барааны тоо чанар, жин, дагалдах эд ангийг шалгах/ хийхтэй холбоотой зардлыг төлөх үүрэгтэй. Худалдагч барааг тээвэрлэхэд шаардлагатай сав баглаа боодлыг өөрийн зардлаар хариуцна. Сав баглаа боодолд тохирсон шошго хадна.

**A 10. Бусад үүрэг**

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр импортом шаардлагатай гарал үүслийн баримт бичгийг гаргаж өгнө. Худалдан авагчид даатгалтай холбоотой шаардагдах мэдээллээр хангана.

**В. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ**

**В 1. Төлбөр**

Худалдан авагч худалдах худалдан авах гэрээний дагуу барааны үнийг төлөх үүрэгтэй.

**В 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдан авагч импортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг импортлоход шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийг өөрийн эрсдэл, зардлаар хариуцна

**В 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдан авагч нэрлэсэн газраас барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар хийнэ. Даатгал хийх үүрэггүй.

**В 4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдан авагч А4-ийн дагуу нийлүүлсэн барааг хүлээн авах үүрэгтэй.

**В 5. Эрсдэл шилжих**

Худалдан авагч бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг

- А4-ийн дагуу бараа нийлүүлэгдсэн үеэс
- Тээвэрлэгч болон бараа хүлээж авах өөр хүнийг томилоогүй, эсхүл түүний томилсон тээвэрлэгч эсхүл өөр хүн А4-ийн дагуу нийлүүлсэн барааг хүлээж аваагүй бөгөөд худалдан авагч энэ тухай зохих журмаар мэдэгдээгүй бол барааны нийлүүлэлтийг хүлээн авах талуудын тохиролцсон хугацаа дууссан өдрөөс эхлэн хариуцна

#### В 6. Зардал

Худалдан авагч нь

- А4 дагуу барааг нийлүүлж хүлээн авснаас хойш гарсан бүх зардал,
- Тээвэрлэгч болон бараа хүлээж авах өөр хүнийг томилоогүй, эсхүл түүний томилсон тээвэрлэгч эсхүл өөр хүн А4-ийн дагуу нийлүүлсэн барааг хүлээж аваагүй бөгөөд худалдан авагч энэ тухай зохих журмаар мэдэгдээгүй бол бараа хүлээж авахаар тохиролцсон хугацаа дууссан үеэс түүнтэй холбоотой үүссэн нэмэлт зардал,
- Барааны импортлохтой холбоотой татвар, хураамж болон гаалийн бүрдүүлэлтэй холбоотой бүхий л зардлыг төлөх үүрэгтэй.

#### В 7. Худалдагчид мэдэгдэл гаргах

Худалдан авагч худалдагчид тээвэрлэгч эсхүл бараа хүлээж авах өөр хүний нэр, мөн шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгслийн төрөл, тодорхойлолтын тухай мэдээлэл, барааг хүлээлгэж өгөх хугацаа, газрын тухай мэдээллийг өгнө.

#### В 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг болон тэдгээртэй адилтгах электрон мэдээлэл

Худалдан авагч А8-ийн дагуу худалдагчаас өгөх нийлүүлэлтийн нотолгоог хүлээн авах үүрэгтэй.

#### В 9. Барааг шалгах

Худалдан авагч барааг ачихаас өмнө хийх шалгалт, түүнээс гадна экспортын улсын эрх бүхий байгууллагын шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй.

#### В10. Бусад үүрэг

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол мөн А3-ийн дагуу тээвэрлэлтийн гэрээг хийхэд туслалцаа үзүүлсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

### **FOB нөхцөл**

**FOB-Free On Board (...named port of shipment)**

**FOB- Усан онгоцны тавцан дээр чөлөөтэй (....нэрлэсэн ачаалах боомт)**

FOB нөхцөл гэдэг нь худалдагч нэрлэсэн усан онгоцны боомт дээрх усан онгоцны тавцан хүртэл барааг хүргэж өгөхийг хэлнэ. Энэ нь тэр цэгээс цааших тухайн барааны зардал болон бараа алга болох, гэмтэх эрсдлийг худалдан

авагч хариуцна гэсэн уг юм. FOB нөхцөл нь худалдагч тухайн барааны экспортын бичиг баримтыг бүрдүүлэхийг шаарддаг.  
Энэ нөхцөл нь гагцхүү далайн болон усан замын тээвэрт хэрэглэгдэнэ.

## **А ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

### **A 1. Бараа**

Худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааг нийлүүлэх мөн худалдааны нэхэмжлэх эсхүл түүнтэй адилтгах электрон бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй.

### **A 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдагч экспортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг экспортод гаргахад шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийн өөрийн эрсдэл, зардлаар хариуцна.

### **A 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдагч барааг тээвэрлэх ба даатгуулах ямар ч үүрэг хүлээхгүй.

### **A 4. Нийлүүлэлт**

Худалдагч барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн ачаалах боомт дээр худалдан авагчийн нэрлэсэн усан онгоцны тавцан хүртэл барааг хүргэж өгөх үүрэгтэй.

### **A 5. Эрсдэл шилжих**

Худалдагч нэрлэсэн ачаалах боомт дээр худалдан авагчийн нэрлэсэн усан онгоцны тавцан хүртэл барааг хүргэж өгөх хүртэл бараа алга болох гэмтэх бүх эрсдлийг хариуцна.

### **A 6. Зардал**

Худалдагч нь

- нэрлэсэн ачаалах боомт дээр худалдан авагчийн нэрлэсэн усан онгоцны тавцан хүртэл барааг хүргэж өгөх хүртэл бүх зардал,
- Экспортын гаалийн бүрдүүлэлт, мөн экспорттой холбоотой татвар хураамж болон бусад зардлыг төлөх үүрэгтэй.

### **A 7. Худалдан авагчид мэдэгдэх**

Худалдагч А4-ийн дагуу барааг хүргэсэн тухай худалдан авагчид мэдэгдэх үүрэгтэй.

### **A 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг**

Худалдагч өөрийн зардлаар нийлүүлэлтийн баталгааг худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй. Худалдагч худалдан авагчийн хүсэлтийн дагуу, түүний эрсдэл зардлаар тээврийн баримт бичгийг гаргаж өгнө.

### **A 9. Шалгах, сав баглаа боодол, шошго**

Худалдагч барааг нийлүүлэхэд шаардлагатай шалгалт /тухайлбал, барааны тоо чанар, жин, дагалдах эд ангийг шалгах/ хийхтэй холбоотой зардлыг төлөх үүрэгтэй. Худалдагч барааг тээвэрлэхэд шаардлагатай сав баглаа боодлыг өөрийн зардлаар хариуцна. Сав баглаа боодолд тохирсон шошго хадна.

## **A 10. Бусад үүрэг**

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспортын орны гаргах баримт бичиг буюу импортод шаардлагатай гарал үүслийн баримт бичгийг гаргаж өгнө. Худалдан авагчид даатгалтай холбоотой шаардагдах мэдээллээр хангана.

## **В. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ**

### **В 1. Төлбөр**

Худалдан авагч худалдах худалдан авах гэрээний дагуу барааны үнийг төлөх үүрэгтэй.

### **В 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдан авагч импортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг импортлоход шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийг өөрийн эрсдэл, зардлаар хариуцна

### **В 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдан авагч нэрлэсэн ачаалах боомтоос барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар хийх үүрэггүй.

### **В 4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдан авагч A4-ийн дагуу нийлүүлсэн барааг хүлээн авах үүрэгтэй.

### **В 5. Эрсдэл шилжих**

Худалдан авагч бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг

- A4-ийн дагуу бараа нийлүүлэгдсэн үеэс
- B7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүй эсхүл худалдан авагчийн нэрлэсэн усан онгоц цагтаа ирээгүй эсхүл бараа хүлээн авах боломжгүй байсан тохиолдолд барааны нийлүүлэлтийг хүлээн авах талуудын тохиролцсон хугацаа дууссан өдрөөс эхлэн хариуцна

### **В 6. Зардал**

Худалдан авагч нь

- A4 дагуу барааг нийлүүлж хүлээн авснаас хойш гарсан бүх зардал,
- Түүний нэрлэсэн усан онгоц цагтаа ирээгүй эсхүл барааг хүлээн авах боломжгүй, эсхүл ачаа хүлээж авах цагийг мэдэгдсэн хугацаанаас өмнө хаасан тохиолдолд худалдан авагч энэ тухай зохих журмаар мэдэгдээгүй бол түүнтэй холбоотой гарсан нэмэлт зардал,
- Барааны импортлохтой холбоотой татвар, хураамж болон гаалийн бүрдүүлэлтэй холбоотой бүхий л зардлыг төлөх үүрэгтэй.

### **В 7. Худалдагчид мэдэгдэл гаргах**

Худалдан авагч худалдагчид усан онгоцны нэр болон очих цаг хугацаа, газрын тухай мэдээллийг өгнө.

### **В 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг болон тэдгээртэй адилтгах электрон мэдээлэл**

Худалдан авагч А8-ийн дагуу худалдагчаас өгөх нийлүүлэлтийн нотолгоог хүлээн авах үүрэгтэй.

#### В 9. Барааг шалгах

Худалдан авагч барааг ачихаас өмнө хийх шалгалт, түүнээс гадна экспортын улсын эрх бүхий байгууллагын шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй.

#### В10. Бусад үүрэг

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

### 3. С БҮЛГИЙН НӨХЦЛҮҮД

#### CFR нөхцөл

**CFR Cost and Freight (...named port of destination)**

**CFR Зардал ба Тээвэрлэлт (...нэрлэсэн очих боомт)**

CFR гэдэг нь худалдагч барааг ачих боомтод усан онгоцны тавцанг өнгөртөл барааг хүргэж өгнө гэсэн үг.

Худалдагч бараа очих боомт хүртэлх бүх шаардлагатай зардал, тээврийн хөлсийг төлөх үүрэгтэй. Гэхдээ бараа алга болох гэмтэх эрсдэл нь барааг хүргэж өгсөн үеэс эхлэн худалдагчаас худалдан авагчид шилжинэ.

CFR нөхцөл нь худалдагч тухайн барааны экспортын бичиг баримтыг бүрдүүлэхийг шаарддаг. Энэ нөхцөл нь зөвхөн далайн болон усан замын тээвэрт хэрэглэгдэнэ.

### А ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ

#### А 1. Бараа

Худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааг нийлүүлэх мөн худалдааны нэхэмжлэх эсхүл түүнтэй адилтгах электрон бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй.

#### А 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт

Худалдагч экспортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг экспортод гаргахад шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийн өөрийн эрсдэл, зардлаар хариуцна.

#### А 3. Тээвэрлэлт ба даатгал

Худалдагч нэрлэсэн очих боомт хүртэл барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар стандарт нөхцлөөр хийх үүрэгтэй. Худалдагч даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

#### **A 4. Нийлүүлэлт**

Худалдагч барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн ачаалах боомт дээр худалдан авагчийн нэрлэсэн усан онгоцны тавцан өнгөртөл барааг хүргэж өгөх үүрэгтэй.

#### **A 5. Эрсдэл шилжих**

Худалдагч А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бараа алга болох гэмтэх бүх эрсдлийг хариуцна.

#### **A 6. Зардал**

Худалдагч нь

- А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бүх зардал,
- А3-ийн дагуу тээврийн болон бусад бүх зардал, түүнээс гадна барааг хөлөг онгоцны тавцан дээр ачих зардал,
- Экспортын гаалийн бүрдүүлэлт, мөн экспорттой холбоотой татвар хураамж болон бусад зардлыг төлөх үүрэгтэй.

#### **A 7. Худалдан авагчид мэдэгдэх**

Худалдагч А4-ийн дагуу барааг хүргэж өгсөн тухай мэдээлэл мөн худалдан авагч барааг хүлээж авахад шаардлагатай арга хэмжээ авахад хэрэгтэй бусад мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

#### **A 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг**

Худалдагч өөрийн зардлаар тээврийн баримт бичгийг худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр тээврийн баримт бичиг нь нийлүүлж буй барааг бүхэлд нь хамарсан, худалдан авагч нэрлэсэн бараа очих боомтоос барааг тээвэрлэгчээс хүлээж авахад шаардлага хангасан байх ёстой. Худалдагч шаардлагатай тохиолдолд тээврийн баримт бичгийг эх хувиар нь худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй.

#### **A 9. Шалгах, сав баглаа боодол, шошго**

Худалдагч барааг нийлүүлэхэд шаардлагатай шалгалт /тухайлбал, барааны тоо чанар, жин, дагалдах эд ангийг шалгах/ хийхтэй холбоотой зардлыг төлөх үүрэгтэй. Худалдагч барааг тээвэрлэхэд шаардлагатай сав баглаа боодлыг өөрийн зардлаар хариуцна. Сав баглаа боодолд тохирсон шошго хадна.

#### **A 10. Бусад үүрэг**

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспортын орны гаргах баримт бичиг буюу импортод шаардлагатай гарал үүслийн баримт бичгийг гаргаж өгнө. Худалдан авагчид даатгалтай холбоотой шаардагдах мэдээллээр хангана.

### **В. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ**

#### **В 1. Төлбөр**

Худалдан авагч худалдах худалдан авах гэрээний дагуу барааны үнийг төлөх үүрэгтэй.

#### **В 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдан авагч импортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг импортлоход шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийг өөрийн эрсдэл, зардлаар хариуцна

**В 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдан авагч тээвэрлэлт болон даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

**В 4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдан авагч А4-ийн дагуу нийлүүлсэн барааг нэрлэсэн очих боомт дээр тээвэрлэгчээс хүлээн авах үүрэгтэй.

**В 5. Эрсдэл шилжих**

Худалдан авагч бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг бараа ачаалах боомт дээр усан онгоцны тавцан өнгөрсөн үеэс эхлэн хариуцна.

**В 6. Зардал**

Худалдан авагч нь

- А4 дагуу барааг нийлүүлж хүлээн авснаас хойш гарсан бүх зардал,
- Барааг нэрлэсэн очих боомтод хүргэх бүх зардал,
- Барааг буулгах зардал, мөн хэмжиж жигнэх зардал,
- В7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүйтэй холбоотой үүссэн нэмэлт зардал
- Барааны импортлохтой холбоотой татвар, хураамж болон гаалийн бүрдүүлэлтэй холбоотой бүхий л зардлыг төлөх үүрэгтэй.

**В 7. Худалдагчид мэдэгдэл гаргах**

Худалдан авагч барааг усан онгоцонд ачих цагийг тодорхойлж, очих боомтын тухай мэдээллийг өгнө.

**В 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг болон тэдгээртэй адилтгах электрон мэдээлэл**

Худалдан авагч А8-ийн дагуу худалдагчаас өгөх тээврийн баримт бичгийг хүлээн авах үүрэгтэй.

**В 9. Барааг шалгах**

Худалдан авагч барааг ачихаас өмнө хийх шалгалт, түүнээс гадна экспортын улсын эрх бүхий байгууллагын шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй.

**В10. Бусад үүрэг**

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

**CIF нөхцөл**

**CIF Cost, Insurance and Freight (...named port of destination)**

## **CIF Зардал, Даатгал, Тээвэрлэлт (...нэрлэсэн очих боомт)**

CIF нөхцөл гэдэг нь худалдагч барааг ачих боомтод усан онгоцны тавцанг өнгөртөл барааг хүргэж өгнө гэсэн үг.

Худалдагч бараа очих боомт хүртэлх бүх шаардлагатай зардал, тээврийн хөлсийг төлөх үүрэгтэй. Гэхдээ бараа алга болох, гэмтэх эрсдэл нь барааг хүргэж өгсөн үеэс эхлэн худалдагчаас худалдан авагчид шилжинэ. Гэсэн хэдий ч CIF нөхцөлд худалдагч нь тээвэрлэлтийн явцад бараа алга болох, гэмтэх зэрэг худалдан авагчид учирч болох эрсдлийн эсрэг далайн тээврийн даатгалыг хийх үүрэгтэй. Иймд худалдагч даатгалын гэрээ байгуулж, даатгалын төлбөрийг төлөх үүргийг хүлээнэ. CIF нөхцөлд худалдагч зөвхөн хамгийн доод хэмжээний даатгалыг төлөх ёстой гэдгийг худалдан авагч мэдэгдэх ёстой. Хэрэв худалдан авагч илүү хэмжээний даатгал хийх хүсэлтэй байгаа бол энэ талаар худалдагчтай тохиролцох эсхүл өөрөө нэмэлт даатгалын арга хэмжээ авна.

CIF нөхцөл нь худалдагч тухайн барааны экспортын бичиг баримтыг бүрдүүлэхийг шаарддаг. Энэ нөхцөл нь зөвхөн далайн болон усан замын тээвэрт хэрэглэгдэнэ.

### **A. ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

#### **A1, A2, A4 - A10**

CFR нөхцлийн A1, A2, A4 –A10-ийг үзнэ үү.

А 3. Тээвэрлэлт ба даатгал

а/ тээвэрлэлтийн гэрээ

Худалдагч нэрлэсэн очих боомт хүртэл барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар стандарт нөхцлөөр хийх үүрэгтэй.

в/ даатгалын гэрээ

Худалдагч гэрээнд тохиролцсоны дагуу даатгалын гэрээг өөрийн зардлаар хийх үүрэгтэй. Энэ тохиолдолд худалдан авагч даатгалын байгууллагаас шууд төлбөрийг нэхэмжлэх боломжтой байх ёстой. Худалдагч худалдан авагчид даатгалын гэрчилгээ болон түүнтэй адилтгах бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй. Худалдагч даатгалын гэрээг зохих хэмжээний нэр хүнд бүхий даатгалын компанийтай даатгалын доод хэмжээгээр хийнэ. Даатгалын доод хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 110 хувь байна.

### **B. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ**

#### **B1- B9**

CFR нөхцлийн B1-B9-ийг үзнэ үү.

В10. Бусад үүрэг

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Худалдан авагч даатгал хийлгэхэд шаардлагатай мэдээлэлийг худалдагчид гаргаж өгөх үүрэгтэй.

## **CPT нөхцөл**

**CPT Carriage Paid To (...named port of destination)**

**CPT Тээвэрлэлтийг төлөх (...нэрлэсэн очих боомт)**

CPT нөхцөл гэдэг нь худалдагч өөрийн томилсон тээвэрлэгч хүртэл барааг хүргэж өгөхөөс гадна нэрлэсэн боомт хүртэл барааг тээвэрлэх зардлыг нэмж төлнө гэсэн үг. Гэхдээ худалдан авагч барааг тээвэрлэгчид хүргэж өгсний дараа бүх эрсдэл, бусад зардлыг төлөх үүрэгтэй.

“Тээвэрлэгч” гэдэг нь тээвэрлэлтийн гэрээний дагуу барааг төмөр зам, авто зам, агаар, далай, эх газрын усан замын тээвэр эсхүл холимог тээврээр ачих, тээвэрлэх үүрэг хүлээсэн этгээдийг хэлнэ.

Хэд хэдэн тээвэрлэгч ашиглаж байгаа тохиолдолд барааг эхний тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн үеэс эрсдэл шилжинэ.

CPT нөхцөл нь худалдагч тухайн барааны экспортын бичиг баримтыг бүрдүүлэхийг шаарддаг. Энэ нөхцлийг тээврийн хэрэгслийн төрлөөс үл хамааран ашиглана. Холимог тээвэрлэлтэд ашиглаж болно.

## **А ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

### **A 1. Бараа**

Худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааг нийлүүлэх мөн худалдааны нэхэмжлэх эсхүл түүнтэй адилтгах электрон бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй.

### **A 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдагч экспортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг экспортод гаргахад шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийн өөрийн эрсдэл, зардлаар хариуцна.

### **A 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдагч нэрлэсэн боомт дээр харилцан тохиролцож заасан газар хүртэл барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар стандарт нөхцлөөр хийх үүрэгтэй. Хэрэв уг газрыг талууд тохиролцоогүй бол нэрлэсэн боомт дээр барааг хүргэх газрыг өөрөө сонгож болно. Худалдагч даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

### **A 4. Нийлүүлэлт**

Худалдагч гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн газар АЗ-ийн дагуу гэрээ байгуулсан тээвэрлэгчид барааг хүргэж өгөх, эсхүл хэд хэдэн тээвэрлэгч оролцож байгаа тохиолдолд эхний тээвэрлэгчид барааг хүргэж өгөх үүрэгтэй.

### **A 5. Эрсдэл шилжих**

Худалдагч А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бараа алга болох гэмтэх бүх эрсдлийг хариуцна.

#### A 6. Зардал

Худалдагч нь

- А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бүх зардал, ачаалах газар барааг ачих, буулгахтай холбоотой зардал,
- Экспортын гаалийн бүрдүүлэлт, мөн экспорттой холбоотой татвар хураамж болон бусад зардлыг төлөх үүрэгтэй.

#### A 7. Худалдан авагчид мэдэгдэх

Худалдагч А4-ийн дагуу барааг нийлүүлсэн тухай мэдээлэл мөн худалдан авагч барааг хүлээн авахад шаардлагатай аргах хэмжээ авахад хэрэгтэй мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

#### A 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг

Худалдагч өөрийн зардлаар тээврийн баримт бичгийг худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй.

#### A 9. Шалгах, сав баглаа боодол, шошго

Худалдагч барааг нийлүүлэхэд шаардлагатай шалгалт /тухайлбал, барааны тоо чанар, жин, дагалдах эд ангийг шалгах/ хийхтэй холбоотой зардлыг төлөх үүрэгтэй. Худалдагч барааг тээвэрлэхэд шаардлагатай сав баглаа боодлыг өөрийн зардлаар хариуцна. Сав баглаа боодолд тохирсон шошго хадна.

#### A 10. Бусад үүрэг

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр импортоод шаардлагатай гарал үүслийн баримт бичгийг гаргаж өгнө. Худалдан авагчид даатгалтай холбоотой шаардагдах мэдээллээр хангана.

### B. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ

#### B 1. Төлбөр

Худалдан авагч худалдах худалдан авах гэрээний дагуу барааны үнийг төлөх үүрэгтэй.

#### B 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт

Худалдан авагч импортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг импортлоход шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийг өөрийн эрсдэл, зардлаар хариуцна

#### B 3. Тээвэрлэлт ба даатгал

Худалдан авагч тээвэрлэлт болон даатгалын асуудлаар ямар нэгэн үүрэг хүлээхгүй.

#### B 4. Нийлүүлэлтийг хүлээн авах

Худалдан авагч А4-ийн дагуу нийлүүлсэн барааг нэрлэсэн газар тээвэрлэгчээс хүлээн авах үүрэгтэй.

#### B 5. Эрсдэл шилжих

Худалдан авагч бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг А4-ийн дагуу бараа нийлүүлэгдсэн үеэс эхлэн хариуцна.

#### В 6. Зардал

Худалдан авагч нь

- А4 дагуу барааг нийлүүлж хүлээн авснаас хойш гарсан бүх зардал,
- Харилцан тохиролцсон газар бараа хүргэх бүх зардал,
- Барааг буулгах зардал,
- В7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүйтэй холбоотой үүссэн нэмэлт зардал
- Барааны импортлохтой холбоотой татвар, хураамж болон гаалийн бүрдүүлэлтэй холбоотой бүхий л зардлыг төлөх үүрэгтэй.

#### В 7. Худалдагчид мэдэгдэл гаргах

Худалдан авагч барааг хүргэх, хугацааны талаарх мэдээллийг худалдагчид өгнө.

#### В 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг

Худалдан авагч А8-ийн дагуу худалдагчаас өгөх тээврийн баримт бичгийг хүлээн авах үүрэгтэй.

#### В 9. Барааг шалгах

Худалдан авагч барааг ачихаас өмнө хийх шалгалт, түүнээс гадна экспортын улсын эрх бүхий байгууллагын шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй.

#### В10. Бусад үүрэг

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол мөн А3-ийн дагуу тээвэрлэлтийн гэрээг хийхэд туслалцаа үзүүлсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

### CIP нөхцөл

**CIP- Carriage and Insurance Paid To (....named port of destination)**

**CIP- Тээвэрлэлт ба Даатгалыг төлөх (....нэрлэсэн очих боомт )**

CIP нөхцөл гэдэг нь худалдагч өөрийн томилсон тээвэрлэгч хүртэл барааг хүргэж өгөхөөс гадна нэрлэсэн боомт хүртэл барааг тээвэрлэх зардлыг нэмж төлнө гэсэн үг. Гэхдээ худалдан авагч барааг тээвэрлэгчид хүргэж өгсний дараа бүх эрсдэл, бусад зардлыг төлөх үүрэгтэй.

CIP нөхцлийн үед худалдагч нь тээвэрлэлтийн явцад бараа алга болох, гэмтэх зэрэг худалдан авагчид учирч болох эрсдлийн эсрэг даатгалыг хийх үүрэгтэй. Иймд худалдагч даатгалын гэрээ байгуулж, даатгалын төлбөрийг төлөх үүргийг хүлээнэ. CIP нөхцөлд худалдагч зөвхөн хамгийн доод хэмжээний даатгалыг төлөх ёстой гэдгийг худалдан авагч мэдэгдэх ёстой. Хэрэв худалдан авагч илүү хэмжээний даатгал хийх хүсэлтэй байгаа бол энэ талаар худалдагчтай тохиролцох эсхүл өөрөө нэмэлт даатгалын арга хэмжээ авна.

“Тээвэрлэгч” гэдэг нь тээвэрлэлтийн гэрээний дагуу барааг төмөр зам, авто зам, агаар, далай, эх газрын усан замын тээвэр эсхүл холимог тээврээр ачих, тээвэрлэх үүрэг хүлээсэн этгээдийг хэлнэ.

Хэд хэдэн тээвэрлэгч ашиглаж байгаа тохиолдолд барааг эхний тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн үеэс эрсдэл шилжинэ.

CIP нөхцөл нь худалдагч тухайн барааны экспортын бичиг баримтыг бүрдүүлэхийг шаарддаг. Энэ нөхцлийг тээврийн хэрэгслийн төрлөөс үл хамааран ашиглана. Холимог тээвэрлэлтэд ашиглаж болно.

## A. ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ

### A1, A2, A4-A10

CPT нөхцлийн A1, A2, A4-A10-ийг үзнэ үү.

A3. Тээвэрлэлт ба даатгал

a/ тээвэрлэлтийн гэрээ

Худалдагч нэрлэсэн очих боомт хүртэл барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар стандарт нөхцлөөр хийх үүрэгтэй.

b/ даатгалын гэрээ

Худалдагч гэрээнд тохиролцсоны дагуу даатгалын гэрээг өөрийн зардлаар хийх үүрэгтэй. Энэ тохиолдолд худалдан авагч даатгалын байгууллагаас шууд төлбөрийг нэхэмжлэх боломжтой байх ёстай. Худалдагч худалдан авагчид даатгалын гэрчилгээ болон түүнтэй адилтгах бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй. Худалдагч даатгалын гэрээг зохих хэмжээний нэр хүнд бүхий даатгалын компанийтай даатгалын доод хэмжээгээр хийнэ. Даатгалын доод хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 110 хувь байна.

### B1- B9

CPT нөхцлийн B1-B9-ийг үзнэ үү.

B10. Бусад үүрэг

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Худалдан авагч даатгал хийлгэхэд шаардлагатай мэдээлэлийг худалдагчид гаргаж өгөх үүрэгтэй.

## 4. Д БҮЛГИЙН НӨХЦЛҮҮД

### DAF нөхцөл

DAF- Delivered At Frontier (...named place)

DAF Хил дээр нийлүүлэгдэх (....нэрлэсэн газар)

DAF нөхцөл гэдэг нь худалдагч нэрлэсэн хилийн боомт дээр заасан газар экспортын бичиг баримтыг бүрдүүлж экспортлогдсон , тээврийн хэрэгслээс буулгаагүй барааг импортын бүрдүүлэлтийг хийлгүйгээр худалдан авагчид хүлээлгэж өгнө гэсэн үг. Гэхдээ бараа хөрш орны гаалийн хилийг нэвтэрээгүй байх ёстой. Хил гэдэгт экспортлогч орны хилийг хамруулан ойлгож болно. Ийм учраас хүрэх хилийн боомт, газрыг нэрлэж өгснөөр хилийн тухай ойлголт тодорхойлогдоно. Хэрэв худалдагч тээврийн хэрэгслээс барааг буулгахгүй байх үүрэг хүлээж, ачаа буулгаагүйн эрсдэл зардлыг худалдагч хариуцахаар талууд тохирсон бол энэ тухай худалдах, худалдан авах гэрээндээ тодорхой зааж өгөх хэрэгтэй. Энэ нөхцлийн тээврийн хэрэгслийн ямар ч төрөлд ашиглаж болно.

## **А ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

### **A 1. Бараа**

Худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааг нийлүүлэх мөн худалдааны нэхэмжлэх эсхүл түүнтэй адилтгах электрон бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй.

### **A 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдагч экспортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг экспортод гаргахад шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийн өөрийн эрсдэл, зардлаар хариуцна.

### **A 3. Тээвэрлэлт ба даатгал**

#### **a/ Тээрлэлтийн гэрээ**

Худалдагч нэрлэсэн хилийн боомт дээр заасан газар хүртэл барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар хийх үүрэгтэй. Хэрэв нэрлэсэн хилийн боомт дээр барааг хүргэх газрыг талууд тохиролцоогүй эсхүл худалдааны практикийн дагуу тодорхойлох боломжгүй бол худалдагч аль болох өөрийн зорилгод нийцсэн газрыг сонгож барааг хүргэж болно.

Мөн худалдан авагчийн хүсэлтээр нэрлэсэн хилийн боомтоос цааш импортлогч улсад худалдан авагчийн нэрлэсэн эцсийн цэг хүртэл барааг тээвэрлэх гэрээг худалдан авагчийн эрсдэл, зардлаар хийж болно.

Худалдагч даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

### **A 4. Нийлүүлэлт**

Худалдагч барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн хилийн боомт дээр заасан газарт барааг тээврийн хэрэгслээс буулгалгүйгээр хүргэж өгөх үүрэгтэй.

### **A 5. Эрсдэл шилжих**

Худалдагч А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бараа алга болох гэмтэх бүх эрсдлийг хариуцна.

### **A 6. Зардал**

Худалдагч нь

- А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бүх зардал,
- Экспортын гаалийн бүрдүүлэлт, мөн экспорттой холбоотой татвар хураамж болон бусад зардлыг төлөх үүрэгтэй.

#### **A 7. Худалдан авагчид мэдэгдэх**

Худалдагч А4-ийн дагуу барааг хүргэж өгсөн тухай мэдээлэл мөн худалдан авагч барааг хүлээж авахад шаардлагатай арга хэмжээ авахад хэрэгтэй бусад мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

#### **A 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг**

Худалдагч өөрийн зардлаар барааг нийлүүлсэн тухай баримт бичиг болон бусад нотолгоог худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй.

Хэрэв худалдагч худалдан авагчийн хүсэлтийн дагуу нэрлэсэн хилийн боомтоос цааших тээвэрлэлтийн гэрээг хийж байгаа бол худалдан авагчийн зардал, эрсдлээр тээврийн баримт бичгийг худалдан авагчид гаргаж өгнө.

#### **A 9. Шалгах, сав баглаа боодол, шошго**

Худалдагч барааг нийлүүлэхэд шаардлагатай шалгалт /тухайлбал, барааны тоо чанар, жин, дагалдах эд ангийг шалгах/ хийхтэй холбоотой зардлыг төлөх үүрэгтэй. Худалдагч барааг тээвэрлэхэд шаардлагатай сав баглаа боодлыг өөрийн зардлаар хариуцна. Сав баглаа боодолд тохирсон шошго хадна.

#### **A 10. Бусад үүрэг**

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспортын орны гаргах баримт бичиг буюу импортод шаардлагатай гарал үүслийн баримт бичгийг гаргаж өгнө. Худалдан авагчид даатгалтай холбоотой шаардагдах мэдээллээр хангана.

### **В. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ**

#### **В 1. Төлбөр**

Худалдан авагч худалдах худалдан авах гэрээний дагуу барааны үнийг төлөх үүрэгтэй.

#### **В 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдан авагч импортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг импортлоход шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийг өөрийн эрсдэл, зардлаар хариуцна

#### **В 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдан авагч тээвэрлэлт болон даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

#### **В 4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдан авагч А4-ийн дагуу нийлүүлсэн барааг нэрлэсэн очих боомт дээр тээвэрлэгчээс хүлээн авах үүрэгтэй.

#### **В 5. Эрсдэл шилжих**

Худалдан авагч бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг А4-ийн дагуу барааг хүлээлгэн өгсөн үеэс эхлэн хариуцна. Худалдан авагч В7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүй бол бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг бараа хүлээн авахаар тохиролцсон хугацаа дууссан үеэс эхлэн хариуцна.

## **В 6. Зардал**

Худалдан авагч нь

- А4 дагуу барааг нийлүүлж хүлээн авснаас хойш гарсан бүх зардал, мөн түүнчлэн нэрлэсэн хилийн боомт дээр ирсэн тээврийн хэрэгслээс барааг хүлээж авахад шаардлагатай бараа буулгах ажиллагаатай холбоотой зардал,
- В7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүйтэй холбоотой үүссэн нэмэлт зардал
- Барааны импортлохтой холбоотой татвар, хураамж болон гаалийн бүрдүүлэлтэй холбоотой бүхий л зардлыг төлөх үүрэгтэй.

## **В 7. Худалдагчид мэдэгдэл гаргах**

Худалдан авагч нэрлэсэн хилийн боомт дээр барааг хүлээн авах газар, цагийн тухай мэдээллийг өгнө.

## **В 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг болон тэдгээртэй адилтгах электрон мэдээлэл**

Худалдан авагч А8-ийн дагуу худалдагчаас өгөх нийлүүлэлтийн нотолгоо болон тээврийн баримт бичгийг хүлээн авах үүрэгтэй.

## **В 9. Барааг шалгах**

Худалдан авагч барааг ачихаас өмнө хийх шалгалт, түүнээс гадна экспортын улсын эрх бүхий байгууллагын шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй.

## **В10. Бусад үүрэг**

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

## **DES нөхцөл**

**DES- Delivered Ex Ship (...named port of destination)**

**DES Усан онгоцноос нийлүүлэх (...нэрлэсэн очих боомт)**

DES нөхцөл гэдэг нь худалдагч импортын гаалийн үзлэгт ороогүй барааг нэрлэсэн боомтод усан онгоцны тавцанд худалдан авагчид хүлээлгэж өгнө гэсэн үг. Худалдагч нэрлэсэн боомтод барааг хүргэж ачааг буулгахаас өмнөх бүх зардал, эрсдлийг хариуцна. Хэрэв барааг буулгах зардлыг худалдагч хариуцааар талууд тохиролцвол мөн энэ нөхцлийг хэрэглэж болно.

DES нөхцөл нь барааг зөвхөн далай болон усан замаар тээвэрлэхэд ашиглагдана.

## **А ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

### **А 1. Бараа**

Худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааг нийлүүлэх мөн худалдааны нэхэмжлэх эсхүл түүнтэй адилтгах электрон бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй.

#### A 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт

Худалдагч экспортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг экспортод гаргахад шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийн өөрийн эрсдэл, зардлаар хариуцна.

#### A 3. Тээвэрлэлт ба даатгал

Худалдагч нэрлэсэн очих боомт дээр заасан газар хүртэл барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар хийх үүрэгтэй. Хэрэв нэрлэсэн боомт дээр барааг хүргэх газрыг талууд тохиролцоогүй эсхүл худалдааны практикийн дагуу тодорхойлох боломжгүй бол худалдагч аль болох өөрийн зорилгод нийцсэн газрыг сонгож барааг хүргэж болно.

Худалдагч даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

#### A 4. Нийлүүлэлт

Худалдагч барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн заасан газар усан онгоцны тавцан дээрээс барааг буулгалгүйгээр хүргэж өгөх үүрэгтэй.

#### A 5. Эрсдэл шилжих

Худалдагч А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бараа алга болох гэмтэх бүх эрсдлийг хариуцна.

#### A 6. Зардал

Худалдагч нь

- А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бүх зардал,
- Экспортын гаалийн бүрдүүлэлт, мөн экспорттой холбоотой татвар хураамж болон бусад зардлыг төлөх үүрэгтэй.

#### A 7. Худалдан авагчид мэдэгдэх

Худалдагч А4-ийн дагуу барааг хүргэж өгсөн тухай мэдээлэл мөн худалдан авагч барааг хүлээж авахад шаардлагатай арга хэмжээ авахад хэрэгтэй бусад мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

#### A 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг

Худалдагч өөрийн зардлаар бараа нийлүүлсэн баримт болон тээврийн баримт бичгийг худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр тээврийн баримт бичиг нь нийлүүлж буй барааг бүхэлд нь хамарсан, худалдан авагч нэрлэсэн бараа очих боомтоос барааг тээвэрлэгчээс хүлээж авахад шаардлага хангасан байх ёстой. Худалдагч шаардлагатай тохиолдолд тээврийн баримт бичгийг эх хувиар нь худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй.

#### A 9. Шалгах, сав баглаа боодол, шошго

Худалдагч барааг нийлүүлэхэд шаардлагатай шалгалт /тухайлбал, барааны тоо чанар, жин, дагалдах эд ангийг шалгах/ хийхтэй холбоотой зардлыг төлөх үүрэгтэй. Худалдагч барааг тээвэрлэхэд шаардлагатай сав баглаа боодлыг өөрийн зардлаар хариуцна. Сав баглаа боодолд тохирсон шошго хадна.

## A 10. Бусад үүрэг

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспортын орны гаргах баримт бичиг буюу импортоод шаардлагатай гарал үүслийн баримт бичгийг гаргаж өгнө. Худалдан авагчид даатгалтай холбоотой шаардагдах мэдээллээр хангана.

## В. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ

### В 1. Төлбөр

Худалдан авагч худалдах худалдан авах гэрээний дагуу барааны үнийг төлөх үүрэгтэй.

### В 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт

Худалдан авагч импортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг импортлоход шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийг өөрийн эрсдэл, зардлаар хариуцна

### В 3. Тээвэрлэлт ба даатгал

Худалдан авагч тээвэрлэлт болон даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

### В 4. Нийлүүлэлтийг хүлээн авах

Худалдан авагч А4-ийн дагуу нийлүүлсэн барааг нэрлэсэн очих боомт дээр тээвэрлэгчээс хүлээн авах үүрэгтэй.

### В 5. Эрсдэл шилжих

Худалдан авагч бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг А4-ийн дагуу барааг хүлээлгэн өгсөн үеэс эхлэн хариуцна. Худалдан авагч В7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүй бол бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг бараа хүлээн авахаар тохиролцсон хугацаа дууссан үеэс эхлэн хариуцна.

### В 6. Зардал

Худалдан авагч нь

- А4 дагуу барааг нийлүүлж хүлээн авснаас хойш гарсан бүх зардал, мөн түүнчлэн усан онгоцноос барааг хүлээж авахад шаардлагатай бараа буулгах ажиллагаатай холбоотой зардал,
- В7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүйтэй холбоотой үүссэн нэмэлт зардал
- Барааны импортлохтой холбоотой татвар, хураамж болон гаалийн бүрдүүлэлтэй холбоотой бүхий л зардлыг төлөх үүрэгтэй.

### В 7. Худалдагчид мэдэгдэл гаргах

Худалдан авагч нэрлэсэн ачаалах боомт дээр барааг хүлээн авах газар, цагийн тухай мэдээллийг өгнө.

### В 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг болон тэдгээртэй адилтгах электрон мэдээлэл

Худалдан авагч А8-ийн дагуу худалдагчаас өгөх тээврийн баримт бичгийг хүлээн авах үүрэгтэй.

### В 9. Барааг шалгах

Худалдан авагч барааг ачихаас өмнө хийх шалгалт, түүнээс гадна экспортын улсын эрх бүхий байгууллагын шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй.

#### B10. Бусад үүрэг

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

#### **DEQ нөхцөл**

**DEQ- Delivered Ex Quay (...named port of destination)**

**DEQ – Бoomтод нийлүүлэгдэх (.....нэрлэсэн очих боомт)**

DEQ нөхцлийн дагуу худалдагч импортын гаалийн бүрдүүлэлт хийгээгүй барааг нэрлэсэн очих боомт дээр худалдан авагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

Худалдагч барааг нэрлэсэн боомт дээр хүргэж өгөх, ачих буулгах бүх зардал, эрсдлийг хариуцна. DEQ нөхцөл нь худалдан авагч импортын гаалийн бүрдүүлэлтийг хийх, үзлэгт оруулах болон импорттой холбоотой бусат татвар, хураамжийг төлөхийг шаарддаг.

Хэрэв талууд импортын гаалийн үзлэгтэй холбоотой зардлын талыг эсхүл бүгдийг нь худалдагчид хариуцна гэж тохиролцвол энэ тухайгаа худалдан худалдан авах гэрээнд нэмж тодорхой бичиж өгөх ёстой.

DEQ нөхцөл нь далайн ба дотоод усан замын тээвэрт хэрэглэгдэнэ.

Хэрэв худалдагчийн үндсэн үүрэг дээр барааг боомтоос өөр ямар нэгэн газар уруу /агуулах, тээвэрлэлтийн эцсийн буудал гэх мэт/ хүргүүлэхбуюубарааг боомтоос гарах үүргийг нэмж оруулахыг талууд хүсвэл DDU болон DDP нөхцлийг ашиглана.

### **А ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

#### A 1. Бараа

Худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааг нийлүүлэх мөн худалдааны нэхэмжлэх эсхүл түүнтэй адилтгах электрон бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй.

#### A 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт

Худалдагч экспортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг экспортод гаргахад шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийн өөрийн эрсдэл, зардлаар хариуцна.

#### A 3. Тээвэрлэлт ба даатгал

Худалдагч нэрлэсэн очих боомт хүртэл барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар стандарт нөхцлөөр хийх үүрэгтэй. Худалдагч даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

#### A 4. Нийлүүлэлт

Худалдагч барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн ачаалах боомт дээр барааг хүргэж өгөх үүрэгтэй.

#### A 5. Эрсдэл шилжих

Худалдагч А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бараа алга болох гэмтэх бүх эрсдлийг хариуцна.

#### A 6. Зардал

Худалдагч нь

- А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бүх зардал,
- А3-т заасан үүргийг гүйцэтгэхтэй холбоотой нэмэлт зардал,
- Экспортын гаалийн бүрдүүлэлт, мөн экспорттой холбоотой татвар хураамж болон бусад зардлыг төлөх үүрэгтэй.

#### A 7. Худалдан авагчид мэдэгдэх

Худалдагч А4-ийн дагуу барааг хүргэж өгсөн тухай мэдээлэл мөн худалдан авагч барааг хүлээж авахад шаардлагатай арга хэмжээ авахад хэрэгтэй бусад мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

#### A 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг

Худалдагч өөрийн зардлаар нийлүүлэлтийн талаарх баримт болон тээврийн баримт бичгийг худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр тээврийн баримт бичиг нь худалдан авагч нэрлэсэн очих боомтоос барааг тээвэрлэгчээс хүлээж авахад шаардлага хангасан байх ёстой. Худалдагч шаардлагатай тохиолдолд тээврийн баримт бичгийг эх хувиар нь худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй.

#### A 9. Шалгах, сав баглаа боодол, шошго

Худалдагч барааг нийлүүлэхэд шаардлагатай шалгалт /тухайлбал, барааны тоо чанар, жин, дагалдах эд ангийг шалгах/ хийхтэй холбоотой зардлыг төлөх үүрэгтэй. Худалдагч барааг тээвэрлэхэд шаардлагатай сав баглаа боодлыг өөрийн зардлаар хариуцна. Сав баглаа боодолд тохирсон шошго хадна.

#### A 10. Бусад үүрэг

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспортын орны гаргах баримт бичиг буюу импортод шаардлагатай гарал үүслийн баримт бичгийг гаргаж өгнө. Худалдан авагчид даатгалтай холбоотой шаардагдах мэдээллээр хангана.

### B. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ

#### B 1. Төлбөр

Худалдан авагч худалдах худалдан авах гэрээний дагуу барааны үнийг төлөх үүрэгтэй.

#### B 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт

Худалдан авагч импортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг импортлоход шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийг өөрийн эрсдэл, зардлаар хариуцна

### **В 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдан авагч тээвэрлэлт болон даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

### **В 4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдан авагч А4-ийн дагуу нийлүүлсэн барааг хүлээн авах үүрэгтэй.

### **В 5. Эрсдэл шилжих**

Худалдан авагч бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг А4-ийн дагуу барааг хүлээлгэн өгсөн үеэс эхлэн хариуцна. Худалдан авагч В7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүй бол бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг бараа хүлээн авахаар тохиролцсон хугацаа дууссан үеэс эхлэн хариуцна.

### **В 6. Зардал**

Худалдан авагч нь

- А4 дагуу барааг нийлүүлж хүлээн авснаас хойш гарсан бүх зардал,
- В7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүйтэй холбоотой үүссэн нэмэлт зардал
- Барааны импортлохтой холбоотой татвар, хураамж болон гаалийн бүрдүүлэлтэй холбоотой бүхий л зардлыг төлөх үүрэгтэй.

### **В 7. Худалдагчид мэдэгдэл гаргах**

Худалдан авагч нэрлэсэн боомт дээр барааг хүлээн авах газар, цагийн тухай мэдээллийг өгнө.

### **В 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг болон тэдгээртэй адилтгах электрон мэдээлэл**

Худалдан авагч А8-ийн дагуу худалдагчаас өгөх тээврийн баримт бичгийг хүлээн авах үүрэгтэй.

### **В 9. Барааг шалгах**

Худалдан авагч барааг ачихаас өмнө хийх шалгалт, түүнээс гадна экспортын улсын эрх бүхий байгууллагын шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй.

### **В10. Бусад үүрэг**

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

## **DDU нөхцөл**

**DDU- Delivered Duty Unpaid (...named place of destination)**

**DDU- Нийлүүлэлтийн Төлбөр Төлөгдөөгүй (.....нэрлэсэн очих газар)**

DDU нөхцлөөр худалдагч нэрлэсэн очих газар импортын гаалийн үзлэгт ороогүй барааг ачиж ирсэн тээврийн хэрэгслээс буулгалгүйгээр худалдан авагчид хүлээлгэж өгнө. Өөрөөр хэлбэл худалдагч нэрлэсэн газар барааг хүргэж өгөхдөө импорттой холбоотой аливаа татвар хураамжийг төлөх үүрэг хүлээхгүй. Дээрх татвар хураамж төлөх үүргийг худалдан авагч хүлээнэ. Хэрэв

тaluуд гаалийн бүрдүүлэлттэй холбоотой зардал, эрсдлийг худалдагчид хүлээлгэхээр тохиролцсон бол энэ тухай худалдах худалдан авах гэрээндээ тусгах нь зүйтэй.

DDU нөхцөл нь бүх тээврийн хэрэгсэлд хэрэглэгдэж болно.

## **А ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

### **A 1. Бараа**

Худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааг нийлүүлэх мөн худалдааны нэхэмжлэх эсхүл түүнтэй адилтгах электрон бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй.

### **A 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт**

Худалдагч экспортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг экспортод гаргахад шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийн өөрийн эрсдэл, зардлаар хариуцна.

### **A 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдагч нэрлэсэн очих боомт хүртэл барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар стандарт нөхцлөөр хийх үүрэгтэй. Худалдагч даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

### **A 4. Нийлүүлэлт**

Худалдагч барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн газар барааг тээврийн хэрэгслээс буулгалгүйгээр хүргэж өгөх үүрэгтэй.

### **A 5. Эрсдэл шилжих**

Худалдагч А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бараа алга болох гэмтэх бүх эрсдлийг хариуцна.

### **A 6. Зардал**

Худалдагч нь

- А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бүх зардал,
- А3-т заасан үүргийг гүйцэтгэхтэй холбоотой нэмэлт зардал,
- Экспортын гаалийн бүрдүүлэлт, мөн экспорттой холбоотой татвар хураамж болон бусад зардлыг төлөх үүрэгтэй.

### **A 7. Худалдан авагчид мэдэгдэх**

Худалдагч А4-ийн дагуу барааг хүргэж өгсөн тухай мэдээлэл мөн худалдан авагч барааг хүлээж авахад шаардлагатай арга хэмжээ авахад хэрэгтэй бусад мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

### **A 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг**

Худалдагч өөрийн зардлаар нийлүүлэлтийн талаарх баримт болон тээврийн баримт бичгийг худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй.

### **A 9. Шалгах, сав баглаа боодол, шошго**

Худалдагч барааг нийлүүлэхэд шаардлагатай шалгалт /тухайлбал, барааны тоо чанар, жин, дагалдах эд ангийг шалгах/ хийхтэй холбоотой зардлыг төлөх

үүрэгтэй. Худалдагч барааг тээвэрлэхэд шаардлагатай сав баглаа боодлыг өөрийн зардлаар хариуцна. Сав баглаа боодолд тохирсон шошго хадна.

#### A 10. Бусад үүрэг

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспортын орны гаргах баримт бичиг буюу импортод шаардлагатай гарал үүслийн баримт бичгийг гаргаж өгнө. Худалдан авагчид даатгалтай холбоотой шаардагдах мэдээллээр хангана.

### **В. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ**

#### B 1. Төлбөр

Худалдан авагч худалдах худалдан авах гэрээний дагуу барааны үнийг төлөх үүрэгтэй.

#### B 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт

Худалдан авагч импортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг импортлоход шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийг өөрийн эрсдэл, зардлаар хариуцна

#### B 3. Тээвэрлэлт ба даатгал

Худалдан авагч тээвэрлэлт болон даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

#### B 4. Нийлүүлэлтийг хүлээн авах

Худалдан авагч A4-ийн дагуу нийлүүлсэн барааг хүлээн авах үүрэгтэй.

#### B 5. Эрсдэл шилжих

Худалдан авагч бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг A4-ийн дагуу барааг хүлээлгэн өгсөн үеэс эхлэн хариуцна. Худалдан авагч B7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүй бол бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг бараа хүлээн авахаар тохиролцсон хугацаа дууссан үеэс эхлэн хариуцна.

#### B 6. Зардал

Худалдан авагч нь

- A4 дагуу барааг нийлүүлж хүлээн авснаас хойш гарсан бүх зардал,
- B7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүйтэй холбоотой үүссэн нэмэлт зардал
- Барааны импортлохтой холбоотой татвар, хураамж болон гаалийн бүрдүүлэлтэй холбоотой бүхий л зардлыг төлөх үүрэгтэй.

#### B 7. Худалдагчид мэдэгдэл гаргах

Худалдан авагч нэрлэсэн газар дээр барааг хүлээн авах газар, цагийн тухай мэдээллийг өгнө.

#### B 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг болон тэдгээртэй адилтгах электрон мэдээлэл

Худалдан авагч A8-ийн дагуу худалдагчаас өгөх тээврийн баримт бичгийг хүлээн авах үүрэгтэй.

#### B 9. Барааг шалгах

Худалдан авагч барааг ачихаас өмнө хийх шалгалт, түүнээс гадна экспортын улсын эрх бүхий байгууллагын шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй.

#### B10. Бусад үүрэг

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

### **DDP нөхцөл**

**DDP- Delivered Duty Paid (...named place of destination)**

**DDP-Нийлүүлэлтийн Төлбөр Төлөгдсөн (...нэрлэсэн очих газар)**

DDP нөхцлөөр худалдагч нь барааны экспортын бүрдүүлэлтийг хийж, импортын үзлэгт орсон боловч тээврийн хэрэгслээс буулгаагүй барааг нэрлэсэн газарт худалдан авагчид хүлээлгэж өгнө. Худалдагч барааг хүрэх ёстой улсын гаалийн үзлэгээр оруулах, түүнтэй холбоотой аливаа татвар, хураамж, зардлыг хариуцна.

EXW нөхцөл ньхудалдагчийн үүргийн хамгийн бага хэмжээг агуулдаг бол DDP нөхцлийн хувьд худалдагчийн хүлээх үүрэг нь хамгийн их байдаг. Худалдагч импортын лицензийг шууд болон шууд бусаар аваагүй тохиолдолд энэ нөхцөл хэрэглэгдэхгүй.

Хэрэв талууд худалдагчийг импорттой холбоотой зарим зардлаас чөлөөлөхөөр харилцан тохиролцвол энэ тухай худалдах худалдан авах гэрээндээ тодорхой зааж өгөх хэрэгтэй. Харин иморттой холбоотой бүх зардал, эрсдлийг худалдан авагчид даалгахыг хүсч байвал DDU нөхцлийг ашиглана.

DDP нөхцөл нь бүх төрлийн тээврийн хэрэгсэлд хэрэглэгдэнэ.

### **А ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

#### A 1. Бараа

Худалдах худалдан авах гэрээнд заасны дагуу барааг нийлүүлэх мөн худалдааны нэхэмжлэх эсхүл түүнтэй адилтгах электрон бичиг баримтыг шилжүүлэх үүрэгтэй.

#### A 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт

Худалдагч экспортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг экспортод гаргахад шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийн өөрийн эрсдэл, зардлаар хариуцна.

#### A 3. Тээвэрлэлт ба даатгал

Худалдагч нэрлэсэн очих боомт хүртэл барааг тээвэрлэх гэрээг өөрийн зардлаар стандарт нөхцлөөр хийх үүрэгтэй. Худалдагч даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

#### A 4. Нийлүүлэлт

Худалдагч барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн газар барааг тээврийн хэрэгслээс буулгалгүйгээр хүргэж өгөх үүрэгтэй.

#### A 5. Эрсдэл шилжих

Худалдагч А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бараа алга болох гэмтэх бүх эрсдлийг хариуцна.

#### A 6. Зардал

Худалдагч нь

- А4-ийн дагуу барааг нийлүүлэх хүртэл бүх зардал,
- А3-т заасан үүргийг гүйцэтгэхтэй холбоотой нэмэлт зардал,
- Экспорт болон импортын гаалийн бүрдүүлэлт, мөн экспорт, импорттой холбоотой татвар хураамж болон бусад зардлыг төлөх үүрэгтэй.

#### A 7. Худалдан авагчид мэдэгдэх

Худалдагч А4-ийн дагуу барааг хүргэж өгсөн тухай мэдээлэл мөн худалдан авагч барааг хүлээж авахад шаардлагатай арга хэмжээ авахад хэрэгтэй бусад мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

#### A 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг

Худалдагч өөрийн зардлаар нийлүүлэлтийн талаарх баримт болон тээврийн баримт бичгийг худалдан авагчид гаргаж өгөх үүрэгтэй.

#### A 9. Шалгах, сав баглаа боодол, шошго

Худалдагч барааг нийлүүлэхэд шаардлагатай шалгалт /тухайлбал, барааны тоо чанар, жин, дагалдах эд ангийг шалгах/ хийхтэй холбоотой зардлыг төлөх үүрэгтэй. Худалдагч барааг тээвэрлэхэд шаардлагатай сав баглаа боодлыг өөрийн зардлаар хариуцна. Сав баглаа боодолд тохирсон шошго хадна.

#### A 10. Бусад үүрэг

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспортын орны гаргах баримт бичиг буюу импортод шаардлагатай гарал үүслийн баримт бичгийг гаргаж өгнө. Худалдан авагчид даатгалтай холбоотой шаардагдах мэдээллээр хангана.

### B. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ

#### B 1. Төлбөр

Худалдан авагч худалдах худалдан авах гэрээний дагуу барааны үнийг төлөх үүрэгтэй.

#### B 2. Зөвшөөрөл, лиценз, гаалийн бүрдүүлэлт

Худалдан авагч импортын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бичиг баримт мөн барааг импортлоход шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийг өөрийн эрсдэл, зардлаар хариуцна

### **В 3. Тээвэрлэлт ба даатгал**

Худалдан авагч тээвэрлэлт болон даатгалын асуудлаар үүрэг хүлээхгүй.

### **В 4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдан авагч А4-ийн дагуу нийлүүлсэн барааг хүлээн авах үүрэгтэй.

### **В 5. Эрсдэл шилжих**

Худалдан авагч бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг А4-ийн дагуу барааг хүлээлгэн өгсөн үеэс эхлэн хариуцна. Худалдан авагч В7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүй бол бараа алдагдах, гэмтэх бүхий л эрсдлийг бараа хүлээн авахаар тохиролцсон хугацаа дууссан үеэс эхлэн хариуцна.

### **В 6. Зардал**

Худалдан авагч нь

- А4 дагуу барааг нийлүүлж хүлээн авснаас хойш гарсан бүх зардал,
- В7-ийн дагуу мэдэгдэл өгөөгүйтэй холбоотой үүссэн нэмэлт зардал

### **В 7. Худалдагчид мэдэгдэл гаргах**

Худалдан авагч нэрлэсэн газар дээр барааг хүлээн авах газар, цагийн тухай мэдээллийг өгнө.

### **В 8. Нийлүүлэлтийн нотолгоо, тээврийн баримт бичиг болон тэдгээртэй адилтгах электрон мэдээлэл**

Худалдан авагч А8-ийн дагуу худалдагчаас өгөх тээврийн баримт бичгийг хүлээн авах үүрэгтэй.

### **В 9. Барааг шалгах**

Худалдан авагч барааг ачихаас өмнө хийх шалгалт, түүнээс гадна экспортын улсын эрх бүхий байгууллагын шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй.

### **В10. Бусад үүрэг**

Худалдан авагч А 10-т дурьдсан бичиг баримт түүнтэй адилтгэх электрон мэдээллийг гаргуулахтай холбоотой бүр зардлыг төлөх үүрэгтэй. Хэрэв энэ асуудалд худалдагч тусласан эсхүл өөрийн зардлаар хийсэн бол худалдагчид гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.